

## Хувиараа Үйлчилгээ Үзүүлэгчдийн Илүү Цагийн Баримт

Энэ баримтат хуудсыг Хувиараа Үйлчилгээ Үзүүлэгчдэд ажлын долоо хоногийн хязгаарлалтын дүрмийг сайн ойлгуулах ба илүү цагийн тухай сайн ойлголттой болоход нь туслахаар үйлдсэн. Үйлчлүүлэгчийнхээ хэргийн менежертэй холбоо барих эсвэл илүү мэдээлэл авахаар [www.dshs.wa.gov/altsa/IPOT](http://www.dshs.wa.gov/altsa/IPOT) руу холбогдоно уу.

### ИЛҮҮ ЦАГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### 1. “Ажлын долоо хоног” гэж юу вэ?

Ажлын долоо хоног нь Ням гарагийн 12.00 (шөнө дундын цаг) цагаас эхэлж, дараагийн Бямба гарагийн өглөөний 11.59 цагт дуусдаг.

#### 2. Ажлын Долоо Хоногийн Хязгаарлалт (WWL) гэж юу вэ?

WWL бол та ажлынхаа долоо хоногт ажиллах үйлчилгээний нийт цагийн хэмжээ, тоо юм. 2016 онд Вашингтон муж нь Хувиараа Үйлчилгээ Үзүүлэгчдийн (ХҮҮ) долоо хоногийн ажиллаж болох цагийн тоонд хязгаарлалт тавьсан. Бүх ХҮҮ нь ажлын долоо хоногийн хязгаарлалттай (WWL) ажилладаг. Та зөвхөн өөрийнхөө WWL –ийн хүрээнд ажиллаж болох ба энэхүү нийт цаг нь таны үйлчлүүлэгчээр эсвэл үйлчлүүлэгчдээр томилогдсон байх бөгөөд танд ажил олгож буй үйлчлүүлэгч нь мөн энэ цагийг хүлээж зөвшөөрөх хууль зүйн эрхтэй байх шаардлагатай. Үйлчлүүлэгч нь өөрсдийнхөө Туслалцааны Төлөвлөгөөд буй сарын цагуудаас илүү ажлын цаг томилох эрхгүй. WWL нь хэрэгцээтэй бүгдэд үйлчилгээний санг боломжтой болгох үүднээс илүү цагийн төлбөрт хяналт тавьдаг байна.

#### 3. DSHS нь миний тогтмол WWL-ийг яаж тодорхойлдог ба би тогтмол WWL-ийг яаж мэдэх вэ?

2016 оны 4 дүгээр сард улсын хууль батлагдсан. Энэ хуулиар бүх ХҮҮ-д нийт WWL нь 40 цагийн тоогоор тогтоогдсон, үүнд 2016 оны 1 дүгээр сард долоо хоногт 40 үйлчилгээний цагаас илүү ажилласан ажилчид тооцогдохгүй. 40 цагаас илүү WWL нь ХҮҮ-ийн 2016 оны 1 дүгээр сарын төлбөрт үйлчилгээний цагийг 4.33-т хувааж, ойролцоох 15 минутанд тохируулж дугуйлсан. 2016 оны 5 дугаар сард DSHS нь 2016 оны 1 дүгээр сард ажиллаж байсан ХҮҮ, ажилчдад тэдний WWL мэдээлэлтэй хамт цахим шуудангаар илгээсэн. Тогтмол WWL нь 65 цагаас хэтрэх ёсгүй. Хэрэв та 2016 оны 1 дүгээр сараас хойш та ХҮҮ-г хийж эхэлсэн бол таны WWL бол 40 цаг гэсэн үг.

#### 4. Хэрэв би тогтмол WWL-ийг буруу тогтоосон байна гэж тооцвол яах вэ?

Хэрэв та өөрийнхөө WWL-ийг буруу тодорхойлогдсон байна гэж бодвол та үйлчлүүлэгчийн хэргийн менежертай холбоо барьж, өргөдөл гаргахад таны DSHS таны ажлын цагийг Вашингтоны Захиргааны Код 388-114-0050 дагуу давтан хянан шалгах болно.

#### 5. Миний тогтмол WWL өөрчлөгдөх үү?

Хэрэв таны тогтмол WWL 60.25 ба 65 цагийн хооронд бөгөөд хуулиар өөрөөр заагдаагүй тохиолдолд 2017 оны 7 дугаар сарын 1-ээс 60 цаг хүртэл буурна. Өөрөөр хэлбэл, таны байнгын WWL хэрэв та ХҮҮ гэж тодорхойлогдсон бол өөрчлөгдөхгүй. Хэрэв та үйлчилгээндээ завсарлага гаргасан, тэгээд дахин өөрийгөө ХҮҮ гэж тодорхойлсон бол таны WWL мөн адил хэвээрээ үлдэнэ.

#### 6. Миний WWL –ийн үйлчилгээний цагуудад ямар үйлчилгээнүүд орсон бэ?

- Хувийн Туслалцаа
- Өвчтөнд Тусламж Үзүүлэх
- Ур Чадвар Олгох Сургалт
- Өндөр Настангуудад Тусламж Үзүүлэх

#### 7. Миний WWL замд өнгөрөөсөн цаг, DSHS –ийн шаардлагатай сургалт, эсвэл төлбөртэй цаг (PTO) зэрэгт үйлчилдэг үү?

Үгүй. Замд өнгөрөөсөн цагууд, DSHS –д оролцох шаардлагатай сургалт ба PTO нь таны WWL-д ордоггүй. Энэ нь та өөрийн WWL хүртэл үйлчлүүлэгчийнхээ зааснаар ажиллаж болох ба долоо хоногт та сургалтад оролцох, зохих газарт хүрэх цаг, PTO авах зэргийг хийх шаардлагатай бол цаг тоолохгүйгээр үйлдэнэ.

## Хувиараа Үйлчилгээ Үзүүлэгчдийн Илүү Цагийн Баримт

### ИЛҮҮ ЦАГИЙН (ИЦ) ТӨЛБӨР

#### 8. Миний илүү цагийг (ИЦ) яаж тооцож байна вэ?

Та ажлын долоо хоногт ажилласны 40 цагийн бүрэн тогтмол хөлс авч байгаа. 40 цагаас илүү цаг ажилласан бол та жирийн хөлснөөс 1.5 удаа илүү хөлс авч байгаа.

IPOne төлбөрийн тогтолцоо нь ажлын долоо хоногт таны ажилласан бүх цагийн төлбөрийг тогтмол хөлсөөр хийдэг ("нийт хэмжээ" гэж тооцно). Энэ нь бүх OT цагт ½ нэмэлт хэмжээ мэт харуулдаг. Энэ нийт хэмжээ нь сүүлчийн төлбөрөөр бүгд хамтран нэмэгдсэн.

*Жишээлбэл:*

*Та долоо хоногт 45 цаг ажилласан ба таны тогтмол хэмжээ цагт \$12 доллар байна.*

*Таны хөлс:*

*45 цаг х цагийн \$12 (нийт хэмжээ) = \$540*

*+ 5 цагийн нэмэлт х \$6 (хагас хэмжээ) = \$30*

*Нийт \$540 + \$30 = \$570*

ИЦ нь Төлбөрийн Нийт Тайлбарт тусгагдсан ба Хөлсийн Салбарт хуваагдсан. Энэ жишээнд Хөлсний Салбар 45 хувийн цаг ба 5 ИЦ цаг харуулж байна.

#### 9. Би замд өнгөрөөсөн цаг, DSHS –ийн шаардлагатай сургалт ба PTO зэргийн ИЦ-ийн төлбөрийг авах уу?

Та замд өнгөрөөсөн цаг, DSHS –ийн шаардлагатай сургалтын төлбөрийг хэрэв таны ажилласан нийт цаг долоо хоногт 40-өөс давсан тохиолдолд авах болно. PTO цагууд ажилласан цаг гэж тооцогдохгүй ба тэр нь ИЦ-ийн төлбөрт орохгүй, тооцогдохгүй.

### ТОГТМОЛ 40 ЦАГИЙН WWL –ТАЙ IPS –УУДАД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

#### 10. Би ажлын долоо хоногт 40 цагаас илүү ажиллаж болох уу?

Та долоо хоногт үйлчилгээ хийсний 40 цагаас илүү хугацаанд ажиллах эрхгүй, хэрэв та DSHS-аас 40 цагаас илүү түр зуурын байдлаар ажиллаж болох онцгой зөвшөөрөл авсан бол ажиллаж болно.

#### 11. Хэрэв би олон төрлийн үйлчлүүлэгчидтэй бол тогтмол WWL –аас илүү хугацаагаар ажиллаж болох уу?

Та өөрийн олон төрлийн үйлчлүүлэгчидтэй тогтолцоог хэдэн үйлчлүүлэгчдээс хамаарахгүйгээр өөрөө тогтмол WWL-ийнхаа дотор багтааж тохируулга хийх ёстой. Хэрэв та нэгээс илүү үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлдэг бол, та өөрийнхөө цагийг тохируулах шаардлагатай болон та үйлчилгээнийхээ цагийг нийтлэн тоолохдоо тогтмол WWL-аас таны ажилласан цаг хэтрэхгүй байх ёстой, үүнээс илүү цаг ажиллаж болохгүй.

#### 12. Хэрэв үйлчлүүлэгч надад зориулж миний тогтмол WWL-аас хэтэрсэн илүү цаг тогтоох сонирхолтой байгаа тохиолдолд би яах вэ?

- Та өөрийнхөө WWL –аас хэтэрч ажиллаж болохгүй гэдгийг тайлбарлаад хэрэв тэгвэл нэмэлт төлбөр шаардах болно гэдгээ тайлбарлана уу. Илүү шаардлагын тухай нэмэлт мэдээлэл авахаар #19-ийг харна уу.
- Өөрийнхөө WWL-аас илүү ажиллах ажлыг үл зөвшөөр.
- Үйлчлүүлэгчдээ нэмэлт ажилтан, үйлчлэгч ав гэж зөвлөнө үү.
- Хэрэв үйлчлүүлэгч нь таны хязгаарлалтыг ойлгохгүй эсвэл нэмэлт үйлчлэгч олж чадаагүй тохиолдолд та үйлчлүүлэгчдээ хэрэг хариуцагч менежертайгаа холбоо барь гэж зөвлөнө үү.
- Яаралтай буюу нэн даруй хэрэгцээний талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл 3-р хуудсын #18 –ыг харна уу.

## Хувиараа Үйлчилгээ Үзүүлэгчдийн Илүү Цагийн Баримт

### 40.25 ЦАГ ЭСВЭЛ ИЛҮҮ ЦАГТАЙ ТОГТМОЛ WWL-ТАЙ ХҮҮ НАРТ ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

#### 13. Би долоо хоногт 40 цагаас илүү хугацаанд ажиллаж болох уу?

Хэрэв та DSHS-аас таны тогтмол WWL 40-өөс илүү байна гэх бичгээр явуулсан мэдэгдэл авсан эсвэл таны түр зуурын тусгай WWL нэмэх хүсэлт дэмжигдсэн тохиолдолд та өөрийн баримтанд заасан тоот цагаар ажил эрхэлж болно.

#### 14. Нэгээс илүү үйлчлүүлэгчидтэй ажиллаж байгаа тохиолдолд би яах вэ?

#11-р асуултын хариуг харна уу.

#### 15. Хэрэв миний үйлчлүүлэгч нэг долоо хоногийн тогтмол WWL –аас илүү хугацаатай ажлын цагаар ажиллахад намайг зохицуулах сонирхолтой бол яах вэ?

Хэрэв доорх дурьдсан бүгд үнэн зөв байвал та өөрийнхөө ажлын цагийг зохицуулах чадвартай байх ёстой. Үүнд:

- Үйлчлүүлэгчид хэрэгцээ гарах; ба
- Нэмэлт цагаар ажиллах нь үйлчлүүлэгчийн нэг сард гаргасан ажлын цагуудаас хэтрэхгүй байх; ба
- Нэг долоо хоногт илүү цагаар ажиллах нь үйлчлүүлэгчийн цаашдын ирэх сарын бусад долоо хоногт гарах чухал хэрэгцээнүүдийг шийдвэрлэж чадахгүй; ба
- Хэрэв та энэ сард өөрийн WWL –ээр ажилласан бол нэг долоо хоногт илүү цаг ажиллах нь таныг сардаа илүү цагаар ажиллан тооцно гэсэн үг биш.

Хэрэв таны WWL 40-өөс илүү байвал, та өөрийнхөө цагийг жирийн илүү цаггүй эсвэл бага цагаар ажилладаг сартай зохицуулан хэрэгцээгээрээ тохируулж болно. Сарын илүү цагийн хэмжээ нь өөрийнхөө WWL-аас 40 цагийг хасаад, үлдэгдэлийг сард тохиох Бямба гарагийн тоогоор үржүүлэхэд тооцоологдон гарч ирнэ.

#### Жишээлбэл:

*Жозегийн WWL 46 цаг байна. Жозегийн ажлын сарын илүү цагийн тоо түүний ажиллаж байгаа сарын Бямба гарагийн тооноос хамаарна.*

*5 Бямба гарагийн т ооцоо:  $46 - 40 = 6 \times 5 = 30$*

*4 Бямба гарагийн т ооцоо:  $46 - 40 = 6 \times 4 = 24$*

*Жозегийн үйлчлүүлэгч нь сардаа их уян хатан цагаар ажиллахыг шаардаж байгаа, ба үүнийг Жозе 5 Бямба гарагтай сард 30 цагаас илүү цаг ажиллахгүй, эсвэл 4 Бямба гарагтай саруудаа 24 цагийн илүү цагаар ажиллаж болно гэсэн үг.*

Хэрэв таны үйлчлүүлэгч тэдний Шинэ Эрх Чөлөө (New Freedom) эсвэл Ахмад Дайчдын Гэрийн Үйлчилгээ (Veteran Directed Homecare Services) гэх байгууллагуудаас санхүүжиж, илүү цаг гаргаж болох тохиолдолд та өөрийнхөө ажлын цагийг WWL-аас илүүгээр тохируулж болно

#### 16. Миний үйлчлүүлэгч намайг тогтмол WWL байгаагаас илүү цагаар сардаа ажиллуулах хүсэлт гаргавал би яах вэ?

#12-р асуултанд хариулсан хариултыг харна уу.

### ТҮР ЗУУРЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЖЛЫН ДОЛОО ХОНОГИЙН ХЯЗГААРЛАЛТ (CSWWL)

#### 17. Түр зуурын CSWWL гэж юу вэ?

Тантай хамтран ажиллаж байгаа үйлчлүүлэгч нь хэрэгцээгээ хангах нэмэлт үйлчлэгч хайж байгаа хугацаанд DSHS-аас таны WWL-г түр зуур ихэсгэх хүсэлт гаргаж болно. DSHS нь танд цахим шуудангаар үүнийг дэмжиж байгаа эсвэл дэмжихгүй байгаа зөвшөөрөл эсвэл татгалзлаа явуулна. Хэрэв зөвшөөрсөн тохиолдолд тэр зөвшөөрөл эхэлсний огноо ба хэзээ дуусах огноог танд бичгээр мэдэгдэх ёстой. Таны үйлчлүүлэгч хуулбар авах болно. Энэ өргөдөл/бичсэн мэдэгдлийг CSWWL өргөдөл гэдэг. DSHS нь үйлчлүүлэгчийн тохирсон сарын цагаас илүү грсан түр зуурын WWL-ийг дэмжихгүй.

## Хувиараа Үйлчилгээ Үзүүлэгчдийн Илүү Цагийн Баримт

### ЯАРЛТАЙ ХЭРЭГЦЭЭНҮҮД

**18. Хэрэв би WWL –ийн бүх цагтаа ажилласан гэвч үйлчлүүлэгчид маань яаралтай ба шуурхай хэрэгцээ гарч, би үйлчлүүлэгчийнхээ эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хангахаар ажлаа үргэлжлүүлэх шаардлагатай бол яах вэ?**

- Байдал аюулгүй ба тогтвор болтол үйлчлүүлэгчтэй хамт бай.
- Хэрэв яаралтай тохиолдолд мөн эрүүл мэндийн яаралтай туслалцаа хэрэгтэй бол 9-1-1 рүү холбоо барь.
- Ажлынхаа өдрийг аюулгүй байдлыг харгалзаж дуусга.
- Хэргийн менежертай дараагийн ажлын өдөр холбогдож байдлыг тайлбарла.

### ИЛҮҮДЭЛ ШААРДЛАГА

**19. Илүүдэл шаардлага гэж юу вэ?**

Илүүдэл шаардлага доорхи тохиолдолд үүсдэг:

- Хэрэв та сардаа өөрийнхөө зөвшөөрлөөс илүү үйлчилгээний цагаар ажиллаж байгаа, эсвэл
- Та DSHS –аас дэмжигдээгүй WWL-аас хэтэрсэн цагаар ажиллаж байгаа,
- Та ажлын долоо хоногт тохирсон замд өнгөрөөсөн байх цагаас хэтэрсэн тооны замын цаг шаардаж байгаа.

**20. Гэрээт Үйлдэл гэж юу вэ?**

Гэрээт үйлдэл гэдэг нь танд DSHS-аас явуулсан мэдэгдлийг хэлнэ. Энэ мэдэгдэл нь танд ажиллахаар тохирсон цагаас илүү цагаар ажилласан эсвэл замд өнгөрөөсөн цаг хэтэрсэн тохиолдлуудыг мэдээлдэг.

**21. Хэрэв би WWL-ээс илүү ажиллах эсвэл замд өнгөрөөх цаг хэтэрвэл яадаг вэ?**

- Шаардлага хэтрүүлсэн тохиолдол бүрт та DSHS-аас дэмжлэггүй илүү цагаар ажиллах шаардлагагүй болохыг тайлбарласан бичгээр үйлдлийг гаргасан гэрээт үйлдэл авах болно. Энэ мэдэгдэлийг таны үйлчлүүлэгчидэд мөн адил тэдний төлөөлөгчид рүү явуулах болно.
- Шаардлага хэтэрсэн гурав дахь тохиолдолд таны гэрээ эцэс болох ба эсвэл та 90 хоног төлбөрөө хүлээн авах чадваргүй болно. Хэрэв таны гэрээ дуусгавар болж байвал та шинэ гэрээ хийх хэрэгцээ гарвал 90 хоног хүлээх шаардлагатай гэсэн үг.
- Хэрэв та ажлын долоо хоногийн цаг замд өнгөрөөх цагийн хязгаарлалтыг байнга давтан зөрчвөл, DSHS таны гэрээг дуусгавар болгож, таньтай дахин гэрээ батлахгүй болно.

**22. Гэрээний үйлдэл миний гэрээний файл дээр хэр зэрэг удаан хадгалагдах вэ?**

Гэрээ үйлдэл бүр гэрээний үйлдлийн мэдэгдэлийн огнооноос 12 сарын дотор нээлттэй байдалтай байдаг. 12 сарын дараа гэрээний үйлдэл хаагддаг.

**23. Би гэрээний үйлдлээс яаж зайлсхийх вэ?**

- Өөрийнхөө ажлын хуваарийг урьдчилан байнга төлөвлөх ба түүнийгээ бичиж бай.
- Хэрэв үйлчлүүлэгчийн хэрэгцээ өөрчлөгдөж та таны WWL –ийг хамрах өөр хуваариар ажиллаж байвал, үйлчлүүлэгчийнхээ хэргийн менежертай яаралтай холбогдох хэрэгтэй.
- Өөрийнхөө ажлын цагийг өөрийнхөө тэмдэглэлийн дэвтэрт ажиллаж байгаа өдөр бүрийн эцэст тэмдэглэл хийх, жирийн цаасан хуанли дээр ч тэмдэглэх нь их тустай байдаг. Та өөрийнхөө WWL –ийн хязгаарт ажиллаж байгаа эсэхээ байнга шалгаж бай.
- DSHS нь танд болон таны ажил олгогч/үйлчлүүлэгчид WWL –ийн хүрээнээс хэтрэхгүй байхад, мөн өөрийнхөө ажлын хуанлийг сайтар удирдахад туслалцаа үзүүлэх нөөцтэй. Энэ нөөцийг [www.dshs.wa.gov/altsa/IPOT](http://www.dshs.wa.gov/altsa/IPOT) хуудсаас сонирхож болно.